

**“ГТХЗНТ” УТҮГ-ЫН 2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2017-06-20

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

“ГТХЗНТ” УТҮГ-ын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөө, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлагыг холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам”, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2018 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан ГТХЗНТ-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалын дагуу гүйцэтгэв.

2018 оны үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн болон зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн төлөвлөгөөний биелэлт, тушаал шийдвэр, түүний хэрэгжилтийн байдал, холбогдох тайлан, бусад баримт бичгийн биелэлтийг үндсэн материал болгон ашиглаж, хариуцан хэрэгжүүлэх болон нэгтгэж өгсөн ажилтнаас лавлаж тодруулсаны үндсэн дээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Гурав. Үнэлэлт

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2018 онд байгуулах үр дүнгийн гэрээнд нийт 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100%-ийн биелэлттэй 25, 70%-ийн хэрэгжилттэй 3, 50%-ийн хэрэгжилттэй 2, 30%-ийн хэрэгжилттэй 5, 10%-ийн хэрэгжилттэй 3, тасарсан 1, хугацаа болоогүй 8 арга хэмжээтэй, хэрэгжилт дундажаар 76,7%-тай байна.

Хүснэгт 1

Арга хэмжээ	Заалтын тоо	Хэрэгжилтийн түвшин							ХБ	Биелэлтийн дүн
		100	90	70	50	30	10	0		
Нийт арга хэмжээ	29	14	-	2	1	3	2	-	7	77,3
Тусгай захиалгат арга хэмжээ	5	-	-	-	1	2	1	1	-	24,0
Манлайллын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	13	11	-	1	-	-	-	-	1	97,6
Бүгд	47	25	-	3	2	5	3	1	8	76,7

Үр дүнгийн гэрээнд дараах ажил удаашралтай байна:

1/ Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж, ЗТХЯ-нд хүргүүлэх;

2/ Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлах;

3/ Төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах, холбогдох байгууллага, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, төмөр замын байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ хэрэгжүүлэх;

4/ Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг: Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага. MNS 6630-3:2016 стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дугаарлалтыг шинэчлэх;

5/ Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

6/ Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх;

7/ Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөх олон улсын болон Европын холбооны стандартуудыг орчуулан боловсруулах;

8/ Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох нийтлэг дүрмийг шинэчлэн боловсруулахад ТББ-тай хамтран ажиллах, тус дүрмийн дагуу сургалтыг зохион байгуулж ажиллах;

9/ Суурь бүтэц дэх хөдөлгөөний өвөл, зуны зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх;

10/ Улсын хэмжээнд ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүн, салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх ажлыг зохион байгуулах;

11/ Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч нарын саналыг нэгтгэн зохицуулалт хийх, монголын талаас зохион байгуулалттай нэгдмэл саналыг ТЗХАБ-ын зөвлөгөөнөөр дэвшүүлж, шийдвэрлүүлж байх зорилгоор Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын хамтарсан комиссын болон экспорт, импорт, транзит ачааны хэмжээг тохиролцох ТЗХАБ-ын 2017-2018 оны хуралд ажиглагчаар оролцох;

12/ ЗТХЯ, ГТХЗНТ, Далайн захиргааны албан хаагчдын орон сууц, Төв, ДЗ-ны оффисын барилгын зураг төслийн ажил боловсруулахад захиалагчийн хяналт тавих, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, санхүүжүүлэх банкныг сонгож барилга угсралтын ажлыг эхлүүлэх, шаардлагатай техникийн нөхцөлүүдийг авах, инженер геологийн дүгнэлт хийлгэх;

13/ Байгууллагын өмч хамгаалах байнгын комиссыг ажиллуулж, өмч хөрөнгийн ашиглалт, эзэмшилтэд тавих хяналтыг сайжруулах.

Үр дүнгийн гэрээнд дараах ажил тасарсан байна:

1/ ГТХЗНТ-ийн Техник эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх

Үр дүнгийн гэрээнд дараах ажлын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна:

1/ Төмөр замын ачааны вагоны үйлдвэрлэлийн объект ТВ 10031-2009 стандартыг орчуулан боловсруулах;

- 2/ Галт тэрэгний хөдөлгөөний 2018-2019 оны өвлийн нэгдсэн зурмаг боловсруулж, батлах;
- 3/ “БТЕГ” ХХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох;
- 4/“МТЗ” ТӨХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох;
- 5/ Төмөр зам болон авто зам хоорондын логистикийн уялдаа холбооны талаар судалгаа хийж, санал боловсруулах;
- 6/ ГТХЗНТ-ийн барилгад суурилуулах тоног төхөөрөмж, техникийн шийдэл боловсруулах;
- 7/ Суурь бүтцүүдийн хөдөлгөөнийг хөдлөх бүрэлдэхүүний тусламжтай хянах ажиллагааг автоматжуулах санал, шийдэл боловсруулах;
- 8/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа ажил, үйлчилгээг нээлттэй мэдээлэх.

3.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Эрх зүйн баримт бичгийн нэр	Хяналтад байгаа заалтын тоо	Хэрэгжилтийн түвшин					Биелэлтийн дүн
		100	70	30	0	ХБ	
Ерөнхийлөгчийн зарлиг	1	1	-	-	-	-	100
Засгийн газрын тогтоол	11	6	1	-	-	4	95,8
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	-	2	-	1	-	46,7
Засгийн газрын албан даалгавар	11	-	10			1	70,0
Бүгд	26	7	13	-	1	5	76,7

Хэрэгжих шатанд байгаа тогтоол шийдвэрийн заалт:

1/ Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 2 дахь заалт “Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмуудын хэрэгжилтийг зохион байгуулан мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Тагнуулын ерөнхий газрын дарга Б.Хурц, эрхлэх ажлынхаа хүрээний үйл ажиллагаанд уг журмуудыг мөрдөж ажиллахыг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.”;

2/ Засгийн газрын 2018.03.27-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлийн 5. Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг сахилга, хариуцлагыг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүн, үр нөлөөг бодитойгоор тооцон ажиллах;

3/ Засгийн газрын 2018.04.04-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлийн ХҮ.2. Ажлын байранд, ажлын цагаар интернет ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" ЗГ-ын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, ЗГ-ын

агентлагийн дарга нар, бүх шатны ЗД, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай.;

4/ Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 2.1, 2.3, 2.4, 2.5, 3.

Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй тогтоол шийдвэрийн заалт:

1/ Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолын 1.2. төсвийн хууль тогтоомж зөрчин төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, өр үүсгэсэн болон тендер шалгаруулалтыг зохион байгуулж үнэлэхдээ холбогдох хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хуульд заасан хариуцлага ногдуулж, гарсан зөрчлийг тухай бүр залруулж ажиллах;

2/ Мөн тогтоолын 1.7.а. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.4-т заасан төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар, техник, эдийн засгийн үндэслэлийг 2018 оны 1 дүгээр сарын 10-ны дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх;

3/ Мөн тогтоолын 1.7.б. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэр, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг улирлын шинж чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулан хуулийн дагуу шалгарсан гүйцэтгэгчтэй 2018 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор гэрээ байгуулж, төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлсэн байх;

4/ Мөн тогтоолын 1.7.в. худалдан авах ажиллагааг цахимаар (tender.gov.mn) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд оруулж нийтэд мэдээлж байх;

5/ Засгийн газрын 2017 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгаврын 2.2.

Хэрэгжээгүй тогтоол шийдвэрийн заалт:

1/ Засгийн газрын 2018.05.16-ны өдрийн хуралдааны 21 дүгээр тэмдэглэлийн 4. Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарласантай холбогдуулан Ерөнхий сайдын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн, зөрчил дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцон ажиллахыг төрийн байгууллагын удирдлагуудад даалгав.

3.3. Сайдын тушаалын хэрэгжилт

Хяналтад байгаа заалтын тоо	Хэрэгжилтийн түвшин						Биелэлтийн дүн
	100	70	30	0	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
16 шийдвэрийн 31 заалт	9	10	-	2	9	1	76,19

Хэрэгжих шатанд байгаа сайдын тушаалын заалт:

1/ ЗТХ-ийн сайдын 2016.06.27-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 174 дүгээр тушаалын 2. Энэхүү төлөвлөгөөний биелэлтийг тухайн салбарын түвшинд зохион байгуулж, чиг үүргийн дагуу туссан арга хэмжээ, гүйцэтгэлийн үр дүнг улирал тутам яаманд тайлагнаж байхыг харьяа агентлаг, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай. /Зам, тээврийн салбарын хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө 2016-2022/;

2/ ЗТХ-ийн сайдын 2017.02.21-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 39 дүгээр тушаалын 2. Албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг МУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг /Б.Цогтгэрэл/-т үүрэг болгосугай.;

3/ ЗТХ-ийн сайдын 2017.05.17-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай” 102 дугаар тушаалын 2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдээлэх ажлыг хэвшүүлэх, мэдээллийн нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор цахимаар Сангийн яаманд, албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яамны ХШҮДАГ-т тайлагнаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайдын шилэн дансны цахим бүртгэлд хамаарах байгууллагууд, Сайдын багцын хөрөнгө оруулалтаар төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлж, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.;

4/ ЗТХ-ийн сайдын 2017.06.07-ны өдрийн “Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай” 115 дугаар тушаалын 4. Хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг холбогдох судалгаа, тооцоо, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг төмөр замын тээврийн салбарын аан, байгууллагуудын удирдлагад даалгасугай.;

5/ ЗТХ-ийн сайдын 2017.09.19-ний өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 185 дугаар тушаалын 2. Төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор ТЗУГ-т ирүүлж байхыг харьяа байгууллагын дарга нарт үүрэг болгосугай. /жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-17/;

6/ ЗТХ-ийн 2017.12.04-ний өдрийн “Нууцын ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 252 дугаар тушаалын 1.2.ЗГ-ын 2017.09.13-ны өдрийн 246 дугаар тогтоолоор батлагдсан дараах журмын холбогдох заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7/ Мөн тушаалын 1.4. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж батлан хэрэгжилтийг хангаж ажиллах;

8/ ЗТХ-ийн сайдын 2018.01.05-ны өдрийн “Зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тушаалын 1.5 Төрийн жинхэнэ албан тушаалд шинээр томилох асуудлыг Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын дагуу шийдвэрлэж, шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгож ажиллах;

9/ ЗТХ-ийн сайдын 2018.01.24-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 13 дугаар тушаалын 2. Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмыг МУ-ын Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулахыг ТЗДТБХЗГ /Б.Артур/, ГТХЗНТ /Г.Ариунбаатар/, МТЗ ТӨХК /Б.Цэнгэл/, УБТЗ ХНН /Д.Жигжиднямаа/ нарт тус тус даалгасугай.;

10/ ЗТХ-ийн сайдын 2018.05.22-ны өдрийн “Ачааны вагонд нэгдсэн тооллого хийх тухай” 109 дүгээр тушаалын 1. Төмөр замын салбарын тээвэрлэлтэд ашиглагдаж буй нийт ачааны вагоны бүртгэлийн зөрчлийг арилгах, нэгдсэн мэдээллийг санг шинэчлэх, онлайн бүртгэлд шилжих, гадаад, дотоод вагоны тоо, төрөл, зориулалтын нарийвчлан тогтоох зорилгоор ачааны вагоныг нэгдсэн тооллогод хамруулах ажлыг зохин байгуулж ажиллахыг ТЗДТБХЗГ /Б.Артур/-д, “ГТХЗНТ” УТУГ-ын захирал /Д.Ариунбаатар/-д, “УБТЗ” ХНН-ийн Замын дарга /Д.Жигжиднямаа/-д тус тус даалгасугай.

Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй сайдын тушаалын заалт:

1/ ЗТХ-ийн сайдын 2017.05.17-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай” 102 дугаар тушаалын 4. Шилэн дансны тухай хууль, тогтоомж зөрчсөн албан тушаалтанд зөрчлийн байдлыг харгалзан хариуцлага тооцож ажиллахыг ЗТХЯ-ны ТНБД /Ж.Бат-Эрдэнэ/, харьяа байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.;

2/ ЗТХ-ийн сайдын 2017.09.05-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 176 дугаар тушаалын 2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг “МТЗ” ТӨХК /Х.Хэрлэн/, Монгол-Оросын хувь нийлүүлсэн УБТЗ ХНН /Д.Жигжиднямаа/, “Болдтөмөр Ерөө гол” ХХК /М.Сүхбаатар/-д, ГТХЗНТ /Т.Ариунбаатар/, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нарт тус тус үүрэг болгосугай.;

3/ ЗТХ-ийн сайдын 2018.01.05-ны өдрийн “Зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 05 дугаар тушаалын 1.4 Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах, хяналт, шалгалт хийх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх зэрэг ажилд оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж байх;

4/ ЗТХ-ийн сайдын 2018.02.08-ны өдрийн “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих тухай” 23 дугаар тушаалын 1.1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-д заасан барааг нийлүүлэх шалгуур шаардлагыг тендерийн баримт бичигт тодорхой зааж, дотоодын үйлдвэрлэгчийн бараа бүтээгдэхүүнийг худалдаж авах чиглэлийг баримтлах;

5/ Мөн тушаалын 1.2. Зам, тээврийн салбарт бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дотоодын үйлдвэрлэгчийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн сонгохыг дэмжих, дотоодын давуу эрх тооцох нөхцлийг тендерийн баримт бичигт тусгаж ажиллах;

6/ Мөн тушаалын 1.3. Дотоодын аж ахуй нэгжүүдийн ирүүлсэн тендерийн үнийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу хийсвэрээр бууруулж тооцох;

7/ Мөн тушаалын 1.4. Тендерт оролцогчдод давуу эрх олгохдоо Сангийн сайдын 2007 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдод давуу эрх олгох аргачлал”-ыг мөрдлөг болгон ажиллах.;

8/ Мөн тушаалын 2. Тендерт оролцогчдод давуу эрх олгосон талаархи мэдээг худалдан авах ажиллагааны улирлын тайланд дэлгэрэнгүй тусган тайлагнахыг харьяа байгууллагуудын дарга нарт даалгасугай.;

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс								
I	11	8	1	1	1	-	-	81,81
II	8	6	1	1	-	-	-	86,87
III	10	6	1	-	2	1	-	72,22
IV	12	8	3	-	-	1	-	88,18
V	8	7	-	1	-	-	-	91,25
VI								
Дүн	49	35	6	3	3	2	-	83,93
Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэс								
I	19	13	3	2	1	-	-	79,47
II	16	11	3	-	1	-	1	88,00
III	17	17	-	-	-	-	-	100
IV	22	16	5	-	1	-	-	88,63
V	18	13	4	1	-	-	-	89,44
VI								
Дүн	92	70	15	3	3	-	1	88,90
Захиргаа, санхүүгийн хэлтэс								
I	28	23	4	-	-	1	-	94,48
II	19	13	4	1	-	-	1	88,88
III	17	14	3	-	-	-	-	93,52
IV	23	20	2	-	1	-	-	92,17
V	27	24	1	1	1	-	-	91,85
VI								
	114	94	14	2	2	1	1	91,51
Дүн	255	199	35	8	8	3	2	88,79

3.7. Захирлын шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын хэрэгжилт

Нэгжийн нэр	Үүрэг даалгавар	Хэрэгжилтийн түвшин								Биелэлтийн дүн
		100	90	70	50	30	10	0	ХБ	
ХЗХБХ	?									
ТМССХ	?									
ЗСХ	?									
Дүн	?									

Жич: Захирлын шуурхай зөвлөгөөний үүрэг даалгаврын биелэлтийн нэгтгэл, хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл байхгүй байна.

3.8. Туслах чанараар баталсан бусад төлөвлөгөөний хэрэгжилт

Төлөвлөгөөний нэр	Төлөвлөсөн арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин					Биелэлтийн дүн
		100	70	30	0	ХБ	
Авлигын эсрэг үйл ажиллагааны	8	3	-	-	-	5	100

Дотоод аудитын ажлын	9	4	4	1	-	-	80,00
Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын	9	3	-	-	2	4	60,00
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны	6	6	-	-	-	-	100
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	10	6	-	-	1	3	85,71
Дүн	42	22	4	1	3	12	84,00

Дөрөв. Санал зөвлөмж

Үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар

1. Үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тасарсан болон хэрэгжилт удаашралтай байгаа 14 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх (ХЗХБХ – 5, ТМССХ – 7, ЗСХ – 1). Тухайлбал:

- Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэх, дугаар олгох журмыг шинэчлэн батлуулах болон Хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн тооллого, бүртгэл хийх ажлыг тайлант сард багтаан, Суурь бүтэц дэх хөдөлгөөний 2017-2018 оны өвлийн зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх ажлыг 2018.07.10-наас өмнө бүрэн дуусгаж ажлын үр дүнг ЗТХЯ-нд албан бичиг, илтгэх хуудас, тайлангаар танилцуулах;

- Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг: Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага. MNS 6630-3:2016 стандартыг хэрэгжүүлэх, дугаарлалтыг шинэчлэх арга хэмжээг VII сарын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

- Хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгох, Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженер, бүтээлүүдээр мэдээллийн сан үүсгэх арга хэмжээг VII сарын төлөвлөгөөнд тусгаж бүрэн хэрэгжүүлж дуусгах, гүйцэтгэл, үр дүнд нь нэгжийн дарга хяналт тавьж ажиллах;

- ГОСТ 33435-2015 Хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй ажиллагаа, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж. Аюулгүй ажиллагааны шаардлага ба хяналтын арга” стандарт, О+Р 941-Мэдээллийн сан болон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал” санамж бичгийн орчуулгын хяналт, сайжруулалтыг дуусгах, холбогдох байгууллагаас санал авах ажлыг VII сард зохион байгуулах;

- ГТХЗНТ-ийн Техник эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлыг хэрэгжүүлэх талаар I-VI сард ямар нэгэн ажил зохион байгуулаагүйд дүгнэлт хийж гарц шийдлээ тодорхойлж ЗТХЯ-нд танилцуулж, дэмжүүлэх;

- Төвийн үндсэн болон мөнгөн хөрөнгийн хагас жилийн тооллогыг VI сард багтаан зохион байгуулж, тайланг танилцуулах;

- ХЗХБХ, ТМССХ хамтран хэрэгжүүлэх “БТЕГ” ХХК, “МТЗ” ТӨХК-ийн төмөр замын мэдээллийн сүлжээнд холбогдох арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа 7-8 сар байгаа тул VII сарын төлөвлөгөөнд тусгаж эхлүүлэх;

- ГТХЗНТ-ийн барилгад суурилуулах тоног төхөөрөмж, техникийн шийдэл боловсруулах, Суурь бүтцүүдийн хөдөлгөөнийг хөдлөх бүрэлдэхүүний тусламжтай хянах ажиллагааг автоматжуулах санал, шийдэл боловсруулах арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа 7-8 сар байгаа тул ТМССХ тус ажлыг хугацаанд нь хэрэгжүүлэх, хүн хүчээ зөв хуваарилж зохион байгуулах;

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаалын хэрэгжилтийн талаар

2. “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газар, Сайдын албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж үр дүн, үр нөлөөг бодитой тооцон ажиллах;

3. Нууц хамгаалах чиг үүргийг аль нэг ажилтанд давхар хариуцуулах эрх, үүрэг, хариуцлагыг ажлын байрны тодорхойлолтод нэмэлтээр тусгаж баталгаажуулах, нууцын зэрэглэлийн тэмдэглэгээний дардасуудыг хийлгэх, нууцтай танилцах албан тушаалтны жагсаалт гарган батлуулах;

Захирлын тушаалын хэрэгжилтийн талаар

4. Төв үүсч байгуулагдсаны 5 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах болон шилэн кабелийн өмчлөлийг төрийн мэдэлд шилжүүлэх асуудлыг судалж санал дүгнэлт гаргах үүрэг бүхий төвийн захирлын 2017 оны А/57, 2018 оны А/38 дугаар тушаалыг хүчингүй болгох;

5. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэх;

6. Салбарын хууль тогтоомж, зарим багц дүрэм, журам болон дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын талаар ажилтнаас ерөнхий мэдлэгийн шалгалтыг тодорхой үе шаттай авах асуудлыг удирдлагатай зөвшилцөн зохион байгуулах;

7. Төвийн захирлын 2017 оны “Албан даалгавар хэрэгжүүлэх тухай” А/74, 2018 оны “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх үр дүн, үр нөлөөг бодитой тооцон ажиллах. Эс бөгөөс хэрэгждэггүй, биелдэггүй заалтыг өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг Захиралтай зөвшилцөж шийдвэрлүүлэх;

8. Ажилтны ээлжийн амралтыг баталсан хуваарь ёсоор эдлүүлэх, түр орлон гүйцэтгэх ажилтанд ажлыг нь албан ёсоор хүлээлцүүлж ҮДГ болон нэгжийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хийдүүлэхгүй, орхигдуулахгүй байхад анхаарч ажиллах;

9. Төвийн захирлын 2018.01.25-ны өдрийн А/07, 2018.04.05-ны өдрийн А/22 дугаар тушаалаар томилогдсон комисс шалгалтын дүнгээ орон тооны бус зөвлөлийн хуралд танилцуулах;

10. Төвийн бэлгэдэл /эмблем лого/-ийг шинэчлэх дизайн гаргах талаар зохион байгуулсан уралдааныг дүгнэх, бүтээл эс шалгарсан бол төвийн Захирлын 2018 оны А/16 дугаар тушаалыг хүчингүй болгох;

11. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг хэрэгжүүлж хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө батлуулж мөрдөж ажиллах;

12. Хөдөлмөрийн дотоод журмын нэмэлт, өөрчлөлтийг нийт ажилтанд танилцуулах;

Нэгжүүдийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар

13. Нэгжийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх ажлыг ҮДГ-тэй уялдуулан төлөвлөх;

14. Нэгжийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн ажлын “хүрэх үр дүн”-г бодитоор тооцох, төлөвлөсөн ажлаа “хэрэгжилт 100%” гэж тайлагнадаг ч ҮДГ-нд тусгагдсан “зорилтот түвшин”-д бүрэн хүрээгүй, үр дүн гараагүй байгаад анхаарах;

Захирлын шуурхай зөвлөгөөний талаар

15. Захирлын шуурхай зөвлөгөөнийг тогтмолжуулах, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцох, үр дүнг тогтмол мэдээлэх;

Туслах чанараар баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар

16. Туслах чанараар баталсан төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь бүрэн гүйцэтгэх, хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж ажиллах.

ТАНИЛЦСАН:

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ХЗХБХ-ИЙН ДАРГА

М.БАТМЯГМАР

ТМССХ-ИЙН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ЗСХ-ИЙН ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн дүн

2018 оны эхний хагас жилийн байдлаар

№	Хяналтад байх арга хэмжээ	2018 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Биелэлтийн дүн	Хэрэгжилтийн түвшин								
				100	90	70	50	30	10	0	Хугацаа болоогүй	Үнэлэх боломжгүй
1	Үр дүнгийн гэрээ	47	76,66	25	-	3	2	5	3	1	8	-
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	26	76,66	7	-	13	-	-	-	1	5	-
3	Сайдын тушаал	31	76,19	9	-	10	-	-	-	2	9	1
4	Сайдын шуурхай хуралдаан	2	100	2	-	-	-	-	-	-	-	-
5	Нэгжүүдийн төлөвлөгөө	255	88,79	199	-	35	-	8	-	8	3	2
6	Захирлын тушаал	91	72,93	46	3	9	8	3	-	9	6	7
7	Захирлын шуурхай зөвлөгөөн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Туслах чанараар баталсан төлөвлөгөө	42	84,00	22	-	4	-	1	-	3	12	-
	Нийт дүн	494	84,52	310	3	74	10	17	3	24	43	10

